



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

175 /175/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.11.10

ҮЙЛ ЯВДАЛ

АЖЛЫН ХЭСЭГ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 327 ДУГААР АНГИ, 085, 329 ДҮГЭЭР ТУСГАЙ САЛБАРТ ...



Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнайгаар ахлуулсан ажлын хэсэг өчигдөр Дорнод аймгийн Чойбалсан хотод байрлах БНМАУ-ын баатар, ЗХУ-ын 4 удаагийн баатар, маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар анги болон Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 085 дугаар тусгай салбаруудад ажиллалаа. Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн хувьд Зэвсэгт хүчний 100 жилийн ойг угтан олон бүтээлч ажил өрнүүлжээ. Тухайлбал, тэд дотоод нөөц бололцоондоо тулгуурлан ангийн жагсаалын талбай, индэр, агуулахын хаалга зэргийг шинэчилсэн байна. Тэрчлэн Монгол

Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсэхийн санаачлан хэрэгжүүлж буй "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөлтэй болохоор зорьж байгаагаа ангийн захирагч, хурандаа Н.Цэцэнхүү ажлын хэсгийнхэнд танилцуулсан юм. Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 085 дугаар тусгай салбарын хувьд ч багагүй ажил өрнүүлж байгаагаа танилцуулсан. Тус салбарын захирагч, хошууч С.Дашдондов салбарын барилга байгууламж 1960 онд ашиглалтад орсон бөгөөд олон жилийн ашиглалтаас шалтгаалж дээврийн болон халаалтын чанар муудсан. Засаж сэргээх

боломжтой боловч хөрөнгө мөнгөний хувьд дутагдалтай тул шийдвэрлэж өгөхийг хүссэн юм. Ийнхүү ажлын хэсгийн бүрэлдэхүүн дээрх анги, салбаруудын үйл ажиллагаа, нөхцөл байдалтай танилцсаны дараа ангийн болон салбарын нийт бие бүрэлдэхүүнийг хүлээн авч уулзсан юм. Энэ үеэр Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай нийт алба хаагчдад хандан хэлсэн үгэндээ "Цар тахлын амаргүй энэ үед эрхэлсэн ажил албаа нэр төртэй хааж байгаа офицер, ахлагч, ажилтан албан хаагч та бүхэнд Батлан хамгаалахын сайдын болон Сайдын зөвлөлийн нэрийн өмнөөс талархал дэвшүүлье.

Манай салбар зөвхөн хугацаат цэргийн алба хаагчдыг цэргийн эрдэмд суралцуулахаас гадна бүхий л талаар зөв бие хүнийг төлөвшүүлэхэд чиглээрэй.

Мөн офицер, ахлагчдынхаа болон хугацаат цэргийн алба хаагчдын амьдрах орчныг сайжруулахын тулд бид "Жишиг цэргийн хотхон" төслийг шат дараатайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Тиймээс ирэх жилийн төсөвт 327 дугаар ангийн цэргийн гал тогооны байр, 085 дугаар салбарын барилга байгууламжийн засварт шаардлагатай хөрөнгийг тусгахыг хичээнэ" хэмээн хэлсэн юм. Уулзалтын төгсгөлд анги, салбарын зарим алба хаагчдыг "Эх орны төлөө", "Дайчин алдар" медалиар шагнасан юм. Ажлын хэсэг өнөөдөр Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 329 дүгээр тусгай салбарт ажиллаж байна.

Тус салбарын тухайд эх орныхоо агаарын дархан хилийг нүд цавчилгүй харуулах эрхэм үүргээ нэр төртэй биелүүлэхийн сацуу салбарын тохижилт, бүтээн байгуулалт, алба хаагчдын нийгмийн хамгаалал, амьдрах ая тухтай орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн ажлуудыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хийж байгаа аж. Энэ тухайгаа ч 329 дүгээр тусгай салбарын захирагч, хошууч О.Батцэнгэл ажлын хэсгийнхэнд танилцуулсан юм.

(Үргэлжлэл нь II нүүрт)

Түүхэнд энэ өдөр

1927 он: Улсын IV хуралд БЦЗ ба Сурган боловруулах газрын тухай илтгэлийг Бүх цэргийн жанжин Х.Чойбалсан тавьжээ.

1970 он: БНМАУ-ын "Соёмбо" тэмдэг бүхий МиГ-17 загварын сөнөөгч онгоцнууд ангийн аэдрмоос хөөрч, анхны шалгах, таниулах нислэгийг хийсэн.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 1	☁️ -15


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	☁️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,850.0	2,853.0
EUR 🇪🇺	3,312.0	3,320.0
CNY 🇨🇳	446.0	450.0
RUB 🇷🇺	40.40	41.00
JPY 🇯🇵	25.10	25.20
KRW 🇰🇷	2.39	2.40

ЗУРХАЙ



2021.11.10 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 6/

ӨВЛИЙН ТЭРГҮҮН ШАРАГЧИН ГАХАЙ САРЫН ЕСӨН УЛААН ХАР НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өнгө зүс сайжирна
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
 07.51-17.21
Барилдлага:
 Идэр
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
 Нэр өнгө
Суудал:
 Төмөр

Энэ өдөр бар жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл, байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, хүүхэд үрчлэн авах, андагй тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, эрдэнийг гадагш өгөх, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр буюу засуулбал өнгө зүс сайжирна.

Артиллерийн ЦЭРЭГ-100

Артиллерчид 100 жилийнхээ ОЙД СЭТГЭЛИЙН ХАНДИВ ӨРГӨСӨӨР БАЙНА

Артиллерийн цэргийн 100 жилийн ойг тохиолдуулан ЦНДС-ийн 1983 оны артиллерийн "А" курсийн төгсөгчдийг төлөөлж хурандаа Д.Жаргалсайхан, дэд хурандаа Ш.Дэлгэрцогт, Б.Лувсан, ахмад Д.Сосорбарам нар 400.000, 1982 оны төгсөгчдийн төлөөлөл Хилийн цэргийн дэд хурандаа П.Энхбаяр, ахмад Х.Цогтсайхан нар тус бүр 100.000, Одесса хотын Цэргийн нэгдсэн дээд сургуулийг артиллерийн мэргэжлээр төгссөн

дэд хурандаа Ч.Ганболд, ахмад Хү.Болд, Ж.Батдорж, Ж.Зориг нар 400.000, Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн ахмад дайчин, дэд хурандаа Ш.Чагнаадорж 100.000 төгрөгийн хандив тус тус өргөж, ойн арга хэмжээнд амжилт хүслээ. Та бүгдийг улаан залаат артиллерийн цэргийн сүлд хийморь мөнхөд ивээж байх болтугай.

МАЦХ-НЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛ



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ


НИЙТ БҮРТГЭГДСЭН 360,367 +941	ЭДГЭРСЭН 465,418	НАС БАРСАН 1,756 +12
----------------------------------	---------------------	-------------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 6238 +106	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 161	ЭДГЭРСЭН 5956
------------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 251,555,027
Эдгэрсэн Нийт: 227,754,662
Нас барсан Нийт: 5,079,719



Цахим шууданд

ӨМНӨД СУДАНЫ БАГАЧУУДЫГ БАЯРЛУУЛАВ



Ө н г е р с ө н д о л о о х о н о г т “Клэр” асрамжийн багачуудад генерал Б.Эрдэнэбат тэргүүтэй “UNMISS” а ж и л л а г а а н ы х а н б и ч и г х э р э г, с у р г а л т ы н х э р э г л э г д э х ү ү н б о л о н т ө р ө л бү р и й н э д зүйлийг гардуулан өгчээ. Мөн энхийг сахиулагчид тулааны урлагийн үзүүлбэр үзүүлж, хүүхэд багачуудыг хөгжөөв.

ЗААХ АРГЫН ЦУГЛАРАЛТ БОЛОВ

Зэвсэгт хүчний 350 дугаар анги

2021 оны 11 дүгээр сарын 8, 9-ний өдрүүдэд 2021-2022 оны сургуулийн жилийн хүрээнд “Цэргийн сургалт бэлтгэл, шинэчлэл” сэдэвт офицерууд болон даргалах албан тушаалын ахлагч нарын заах аргын цугларалт амжилттай явагдаж өндөрлөлөө.



“ГАР БӨМБӨГ”-ИЙН ТЭМЦЭЭН БОЛЛОО

Зэвсэгт хүчний 325 дугаар анги



Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн хамт олон “Монгол бахархлын өдөр”-ийг тохиолдуулан бие бүрэлдэхүүнийхээ амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх, гар нийлэмжтэй ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд бие бүрэлдэхүүнийхээ дунд гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж явууллаа. Тэмцээнд нийт 10 баг тамирчид авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс Б.Мөнгөнбаяр ахлагчтай баг тамирчид тэргүүн байрт, дэд ахлагч Т.Билэгсайхан ахлагчтай баг тамирчид дэд байрт, дэд хурандаа Д.Батдаваа ахлагчтай баг тамирчид гутгаар байрт тус шалгарч өргөмжлөл, медалийн эзэд боллоо.

АХМАД Н.МӨНХБААТАР

АЖЛЫН ХЭСЭГ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 327 ДУГААР АНГИ, 085, 329 ДҮГЭЭР ТУСГАЙ САЛБАРТ ...



(Түрүүч нь I нүүрт)

Салбарын хүний нөөцийн хангалт бүрэн, өгөгдсөн ажил үүргийн бүтээмж өндөр байгааг дэд сайд Б.Баярмагнай, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хурандаа С.Ганбямба болон ажлын хэсгийн бусад бүрэлдэхүүн сайшаасан бөгөөд тулгамдсан асуудал болох авто машин, олон жилийн улмаас ашиглагдах боломжгүйд хүрээд байгаа цахилгаан дамжуулах шонгийн асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэж

өгөхөө мэдэгдлээ. Ийнхүү тус салбарын үйл ажиллагаатай танилцсаны төгсгөлд мөн эрхэлсэн ажил, албандаа итгэл зүтгэл гаргасан зарим алба хаагчдыг “Эх орны төлөө”, “Дайчин алдар” медалиар шагнасан юм. Ташрамд дурдахад Дорнод аймгийн Халх гол сум 2019 онд Монгол Улсын Ерөнхийлөгч асан Х.Баттулгын санаачилгаар хэрэгжүүлж байсан “Шинэ сум” төслийн хүрээнд сургууль, цэцэрлэг, соёлын төв, сумын удирдлагын ордон гэх мэтчилэн

барилга байгууламжуудыг шинээр барьж иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн билээ. Халх гол сумын удирдлагуудтай уулзалт хийх үеэр сумын удирдлагууд өмнө ашиглагдаж байсан сургуулийн барилгыг засварлан тохижуулж, тусгай салбарын байрыг өргөтөн ашиглах боломжтой гэдгийг ажлын хэсэгт санал болгосон юм. Үүний дагуу ажлын хэсэг тус барилга байгууламжтай танилцсан юм. Ажлын хэсэг өнөөдөр Их говийн гарнизоныг зорино.

“ХОВД” ЦЭРГИЙН ХҮРЭЭНД АНХ УДАА САХИЛГЫН ЗӨВЛӨГӨӨНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



“Ховд” цэргийн хүрээний анги, байгууллагуудын дунд энэ сарын 3-ны өдөр сахилгын зөвлөгөөнийг зохион байгууллаа. Энэхүү зөвлөгөөнд Ховд аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 123 дугаар анги, Хилийн цэргийн 0130 дугаар отряд, Ховд аймаг дахь Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 457 дугаар хорих анги, Шүүхийн шинжилгээний газрын удирдлага, алба хаагчдын төлөөлөл оролцсон юм.

Уг зөвлөгөөний зорилгон “Ховд” цэргийн хүрээнд харьяалагдах төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчид харилцан мэдээлэл солилцох, гэмт хэрэг, сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аливаа сахилгын зөрчил, осол, гэмтлийг бүрэн арилгаж, ажлын

хариуцлага, сахилга, дэг журмыг бэхжүүлэхэд чиглэгдсэн юм. Зөвлөгөөнийг нээж Ховд аймгийн Засаг дарга Б.Дүгэржав үг хэлсний дараа Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч, хурандаа Х.Энхболд ЗХЖШ-ын даргын 2021 оны Б/669 дүгээр тушаалаар батлагдсан Цэргийн цагдаагийн тасгийн үүрэг, ажиллах журам, “Ховд” ц э р г и й н хүрээ, хотхонд ц э р г и й н цагдаагийн ү й л а ж и л л а г а а г хэрхэн зохион байгуулах т а л а р м э д э э л л хийлээ.

Тэрчлэн зөвлөгөөний төгсгөлд З э в с э г т хүчний 123 дугаар ангийн бие бүрэлдэхүүн “Гэмт хэрэг, сахилгын зөрчилгүй хамт олон” болох уриалгыг

гарган “Сахилга, хариуцлагыг дээшлүүлэх сарын аян”-ыг эхлүүлсэн тухайгаа мэдэгдэв. Энэхүү аяны хүрээнд “Ховд” цэргийн хүрээний анги, байгууллагуудын бие бүрэлдэхүүнд хууль, дүрмийг сурталчлан таниулах сургалт явуулж, хэрэгжилтийг нь хангахад дэмжлэг үзүүлэхээс гадна төрөл бүрийн уралдаан,



тэмцээнийг зохион байгуулахаар төлөвлөөд байна. **Ахмад У.БАТЦЭНГЭЛ**